

МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН 2021 ОНЫ ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын нэр:	МЦХ ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал		
Огноо:	2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр 11:00-14:00	Уулзалтын газар:	Цахим, Zoom програмаар зохион байгуулагдав. URL: telecommongolia.mn/news/shm2021
Хурлын дарга:	Чулуунбатын Пүрэвсүрэн, МЦХ ХК-ийн Инновц, бизнес хөгжлийн газрын ахлах менежер		
Тооллогын комисс:	Тооллогын комиссын дарга Д.Ганцэцэг, Дотоод аудитын газрын мэргэжилтэн Гишүүд: Б.Ариунгэрэл, Удирдлага хүний нөөцийн газрын ахлах менежер О.Содбаяр, Хууль, гадаад харилцааны албаны мэргэжилтэн		
Хурал зохион байгуулах комисс:	Зохион байгуулах комиссын дарга Д.Болдбаатар, Чанарын хяналтын албаны ерөнхий менежер Гишүүд: Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ж.Азбаяр, Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер		
Оролцсон хувьцаа эзэмшигчид	1. М.Шигшээ	Хувьцааны тоо 4 ширхэг	Компанийн нийт гаргасан хувьцааны тоо 25,870,276 ширхэг. Үүнээс нийт 24,500,642 ширхэг саналын эрх бүхий 11 хувьцаа эзэмшигч оролцсон.
	2. Г.Батнасан	Хувьцааны тоо 15 ширхэг	
	3. Д.Доржсүрэн	Хувьцааны тоо 245 ширхэг	
	4. М.Цэцгээ	Хувьцааны тоо 450 ширхэг	
	5. В.Дарханбаатар	Хувьцааны тоо 10,355,683 ширхэг	
	6. В.Дарханбаатар	Хувьцааны тоо 14,143,604 ширхэг	
	7. М.Алтан-Очир	Хувьцааны тоо 210 ширхэг	
	8. С.Нямсайхан	Хувьцааны тоо 130 ширхэг	
	9. Ж.Энхтунгалаг	Хувьцааны тоо 100 ширхэг	
	10.МЖХЭНХ	Хувьцааны тоо 1 ширхэг	
	11.М.Отгонбаяр	Хувьцааны тоо 200 ширхэг	
Ирц:	94.71%		

ХЭЛЭЛЦСЭН нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай
4. 2019 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай
7. Охин компани байгуулах тухай

СОНССОН нь:

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц бүртгэхэд нийт 25,870,276 ширхэг хувьцаанаас 24,500,642 ширхэг саналын эрх бүхий 10 хувьцаа эзэмшигч ирж хурлын ирц 94.71 хувьтай байгаа тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хүчин төгөлдөр болохыг мэдэгдэж байна.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: МЦХ ХК-ийн 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирц хурал хүчинтэй байх хэмжээнд бүрдсэн байна. Ингээд хурлыг эхлүүлж, хурлын дэгийг танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Хурлын дэгийн дагуу хэлэлцэх асуудлаар танилцуулга хийх илтгэгчдийг индэрт урьж, танилцуулга хийлээ. Үүнд:

Нэгдүгээр хэлэлцэх асуудлаар

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай.

Хэлэлцэх асуудлаар Компанийн 2020 оны үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат, тайлангийн талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийн тогтоолыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа нар тус тус танилцууллаа.

Хоёрдугаар хэлэлцэх асуудлаар

2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар танилцуулгыг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Ж.Баасандорж танилцууллаа.

Гуравдугаар хэлэлцэх асуудлаар

3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлт, тайланг Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Ц.Норовжамц танилцууллаа.

Дөрөвдүгээр хэлэлцэх асуудлаар

4. 2019 оны ногдол ашиг тараасан тайлан танилцуулах тухай

Хэлэлцэх асуудлаар 2019 оны ногдол ашиг тараасан тайланг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Санхүү бүртгэл, аж ахуйн газрын захирал Ж.Баасандорж танилцууллаа.

Тавдугаар хэлэлцэх асуудлаар

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн танилцуулгыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Зургаадугаар хэлэлцэх асуудлаар

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай

Хэлэлцэх асуудлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийн төслийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Х.Цэцэгмаа танилцууллаа.

Долоодугаар хэлэлцэх асуудлаар

7. Охин компани байгуулах тухай

Хэлэлцэх асуудлаар охин компани байгуулах тухай Монголын цахилгаан холбоо ХК-ийн Гүйцэтгэх захирал Б.Чинбат, охин компанийн дүрмийн танилцуулгыг Удирдлага, хүний нөөцийн газрын Хууль, гадаад харилцааны албаны ерөнхий менежер Ж.Азбаяр нар тус тус танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудалтай холбоотой мэдээлэл танилцуулгыг хийж дууслаа. Хурлын дэгийн дагуу асуулт, хариулт, саналын хэсэг байгаа. 30 минутад хийхээр төлөвлөсөн. Асуулттай цахимаар оролцож байгаа хувьцаа эзэмшигчид, мөн Төрийн төлөөллийг хэрэгжүүлж байгаа төлөөлөгч студид биечлэн ирсэн байгаа. Хувьцаа эзэмшигч нараас гүйцэтгэх удирдлага болон төрийн төлөөллөөс асуулт байвал асууж боломжтой. Асуулт байвал гараа өргөөд микрофоноо нээгээд, хувь хүн эсвэл хуулийн этгээд бол түүний нэрээ хэлээд асуултаа асуугаарай.

Асуулт хариулт, санал:

Монголын жижиг хувьцаа эзэмшигчдийн нэгдсэн холбоо (Л.Цэвээнравдан): Хувьцаа эзэмшигчдийнхээ амрыг эрье. Илтгэл нэлээн дэлгэрэнгүй, сайн боллоо гэж үзэж байна. Ер нь ногдол ашгийн талаар нэг юм бодож байна. Компанийн нэгж хувьцааны ханш 388 орчим төгрөг байна. Бид түүндээ нэг төгрөгийн ногдол ашиг авч байна. Нэгж хувьцаанд оногдох ашгийг нэмэгдүүлэх талаар бодох асуудал байгаа юу. Хоёрдугаар, компанийн нийгмийн хариуцлага, компанийн засаглалын чиглэлээр нээлттэй ил тод байх, шударга байх энэ талаар ямар бодлоготой явдаг вэ? Өөрөөр хэлбэл компанийн засаглалыг сайжруулах, хувьцаа эзэмшигчдийн төлөө анхаарах, тэдний ашгийг хамгаалах чиглэлээр юу хийх вэ? Яагаад гэвэл манай компанийн хувьцааны 5.3 хувь нь 3900 гаруй хувьцаа жижиг эзэмшигч нар байгаа. Бусдыг нь төр эзэмшиж байна. Бидний хувьд өнөөдөр хурал дээр санал өгөх бол их ач холбогдолгүй шүү дээ. Төрийн төлөөлөл ганц гараа өргөө л 95 хувьтай хурлын шийдвэр гарчихна. Хувьцаа эзэмшигчид бид шийдвэрт нөлөөлөхгүй, хуралдаа орж байгаа нь л их юм. Тийм учраас компаниас ил тод, шударга үйл ажиллагаа явуулах, компанийн засаглалыг сайжруулах чиглэлээр анхаарах хэрэгтэй гэж бодож байгаа юм. Бидний мэдээлэл авдаг суваг бол хөрөнгийн биржийн сайт. Тийм учраас тэн дээр тавьдаг мэдээллийн ил тод байдлыг илүү сайн сайжруулах ёстой гэж бодож байна. Гуравдугаарт, Саяны энэ хурлын материалыг хэвлэмэл байдлаар ямар брокерын компаниар дамжуулан тараасан бэ? Хэвлэх байдлаар тараасан уу үгүй юу уу?

Б.Чинбат, Гүйцэтгэх захирал: Ажлаа аваад гурван сар гаруй болж байна. Энэ хугацаанд компанийн бүтцийн өөрчлөлтийг хийгээд шинэ удирдлага, шинэ менежментийг баг ажилдаа ороод ажиллаад сар гаруй болж байна. Шат дараатай хийгдэх ажлууд хийгдээд явж байна. Компанийн дотоод дүрэм журмаа сайжруулах, дотоод бичиг баримтуудыг шинэчлэх асуудлууд хийгдээд явж байна. Мөн компанийн үйл ажиллагааг цахимжуулах, чиглэлээр ажлууд хийгдэж байна. Шинэ бүтцээр “Мэдээлэл технологийн төв” гэдэг төвтэй болсон байгаа. Энэ төв дээр компанийн вэб сайтыг шинэчлэх, вэб сайтаараа дамжуулан харилцагчид болон хувьцаа эзэмшигчид, олон нийтэд мэдээллээ нээлттэй хүргэх асуудлууд ойрын хугацаанд хийгдээд явна. Компанийн дотоод процессын үйл ажиллагааг цахимжуулах асуудал энэ төв дээр хийхээр төлөвлөгдөж байна. Энэ жил нэлээн ахиж гарга гэж бодож байна. Энэ жил хэрэглэгчдээс ирж байгаа гомдол саналыг бууруулах, техникийн найдвартай бэлэн байдлыг хангах, үйлчилгээний чанарт тэргүүн зорилт болгон анхаарч

ажиллана. Тэгэхээр компанийн үйл ажиллагаа сайжирч, нээлттэй болохын хирээр хувьцааны үнэ, нэгж хувьцаанд ногдох ногдол ашиг нэмэгдэх байхаа гэж тооцож байгаа.

Х.Цэцэгмаа, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга: Хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдээллийг цаасан байдлаар тараах асуудлын хувьд Санхүүгийн зохицуулах хорооноос цар тахалтай холбоотойгоор хувьцаат компаниудыг аль болох биечлэн хуралдахгүй, цахимаар зохион байгуулахыг даалгасан учраас хэвлэмэл болон, цаасан байдлаар материал тараагдаагүй. Хурлын материалыг файлаар, компанийн вэбсайтад хуулаад, дэлгэрэнгүй мэдээллийн хамт компанийн вэбсайтаас авах боломжтой байхаар нээлттэйгээр тавьсан байгаа. Мөн хурлын материалын файлыг брокер, диллерийн компаниудын мэйлинг листээр файл хэлбэрээр линкийг явуулж тараасан байгаа. Компанийн сайтаар орвол мэдээлэл нээлттэй тараагдаж байгаа.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Өнгөрсөн дөрвөн жилд Стратеги төлөвлөлтийн газрын даргын ажлыг хийж гүйцэтгэсэн. Тэгээд хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг, жижиг хувьцаа эзэмшигчдийн саналууд хир тусгагдаж байна. Эрх ашгийг нь бүрэн хамгаалж, анхаарч чадаж байгаа юу уу гэдэг талаар Цэвэрнравдан гуай асуулт тавьлаа. Нэмэлт мэдээлэл хэлмээр санагдлаа. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2019 онд төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой хувьцаат компаниудын Компанийн засаглалын үнэлгээг Монголын компанийн засаглалын хөгжлийн төвтэй хамтраад нилээн өндөр ач холбогдолтой үнэлгээний судалгааг олон улсын түвшинд нарийн гаргасан. Бодит үйл ажиллагаатай танилцаад үнэлгээ өгч ажилласан. Нийт арван компанид үнэлгээ хийсэн, Эрдэнэс таван толгой ХК, Дулааны цахилгаан станц, АЗЗА ХК, Монголын хөрөнгийн бирж ХК гээд шалгалтад оролцсон. Энэ шалгаруулалтад Монголын цахилгаан холбоо ХК нийт үнэлгээгээрээ хоёрдугаарт жагссан. Тэр дундаа Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулах, хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн зөв зохистой зохион байгуулах, мэдээлэл хүргэх тал дээр хамгийн өндөр үнэлгээ авсан. Энэ үнэлгээ бол олон улсын аргачлалаар хийгдсэн учраас компанийн засаглалын үнэлгээ сайн байгаа гэсэн дүгнэлт хийхүйц харьцангуй үнэлгээ боловч бид бас хичээж ажиллаж байгаа юм байна аа гэж дүгнэгдсэн байгаа. Энэ зөвлөмжийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөл сайн ажиллах хэрэгтэй байгаа. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээс хамаарсан, журмууд, журамлах ажлууд хийх шаардлагууд байгаа. Энэ чиглэлээр төлөвлөсөн ажлууд хийгдээд явах байхаа гэж бодож байна.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Баярлалаа. өөр асуулттай хүмүүс гараа өргөж болно.

... Ингээд асуулт, санал өгч дууссан байна гэж тооцоод асуулт хариулт, саналын хэсгээ өндөрлөх үү?

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Хувьцаа эзэмшигчдээс онцгойлон түдгэлзэх зүйл байхгүй байна гэж ойлголоо. Ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын асуулт, хариулт, саналын хэсгийн өндөрлөө. Хуралдаа идэвхтэй оролцож байгаа та бүхэнд маш их баярлалаа.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Санал хураалтын хэсэг эхэлсэн байна. Та бүхэн саналаа цахимаар өгөх, ID нууц үгийг урьдчилан хүлээн авсан байгаа. Манай санал өгөх vote.telecommongolia.mn гэсэн сайтаар ороод ID, нууц үгээ оруулаад саналаа өгөх боломжтой. Хурлаар 7 асуудал хэлэлцсэн. Үүнээс 6 нь үндсэн шийдвэр гаргах асуудал байгаа. 5 асуудал дээр зөвшөөрөх, татгалзах гэдгийг сонгох байгаа. Нэг асуудал нь Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудал байгаа. Та бүхэн куммуллятор арга буюу саналын эрхийн хувьцааныхаа тоогоор саналаа өгөх байгаа. Энэ дээр анхааралтай хандах байх. Санал өгөх хугацааг 5 минутаар өгсөн. Та бүхэн урьдчилаад өгөх боломжтой.

Цахимаар саналаа өгөх тул тооллогын комиссын дүн харьцангуй хурдан гарах байх. Тооллогын комиссын дүн гаргах хугацаа дэгийн дагуу 15 минут байгаа. Та бүхэн энэ хугацаанд Zoom програмаасаа гарахгүй байж болно.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: Тооллогын комиссын дүн гарсан байна. Тооллогын комиссын тооллогын дүнг танилцуулахаар тооллогын комиссын дарга Ганцэцэг индэрт гарч ирсэн байна.

Д.Ганцэцэг, Тооллогын комиссын дарга: Санал хураалтын дүн, тооллогын комиссын тогтоолыг танилцуулав.

Ч.Пүрэвсүрэн, хурлын дарга: 2021 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолыг уншиж танилцуулан хурлыг хаав.

Санал хураалтын дүнгийн тухай:

Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд 24,500,312 ширхэг хувьцаа эзэмшиж буй 9 хувьцаа эзэмшигч саналаа өгсөн байна. Үүнээс 9 саналын хуудас хүчинтэй, саналын хуудас хүчингүй байхгүй байна.

Саналын хуудсанд 6 асуудал шийдвэрлүүлэхээр оруулсан бөгөөд асуудал тус бүрээр доорх санал өгсөн байна. Үүнд:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай нэгдүгээр асуудалд
Зөвшөөрсөн 9 санал буюу 100 хувь 24,500,312 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах тухай хоёрдугаар асуудалд
Зөвшөөрсөн 9 санал буюу 100 хувь 24,500,312 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай гуравдугаар асуудалд
Зөвшөөрсөн 9 санал буюу 100 хувь 24,500,312 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай тавдугаар хэлэлцэх асуудалд Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдэд кумулятив аргаар санал өгснөөс

Ердийн гишүүнд нэр дэвшигч:

Т.Лхагвасүрэнд	24,500,347 ширхэг хувьцааны санал
Г.Эрдэнэбулганд	24,500,297 ширхэг хувьцааны санал
Ц.Цэвэгдоржид	24,500,297 ширхэг хувьцааны санал
Ж.Цогтбаярт	24,500,297 ширхэг хувьцааны санал
Ц.Шинэхүүд	24,500,297 ширхэг хувьцааны санал
М.Лхагважавт	24,500,337 ширхэг хувьцааны санал

Хараат бус гишүүнд нэр дэвшигч:

Ц.Норовжамцад	24,500,306 ширхэг хувьцааны санал
Ж.Тамирт	24,500,297 ширхэг хувьцааны санал
Ю.Бат-Эрдэнэд	24,499,773 ширхэг хувьцааны санал

Л.Болормаад 560 ширхэг хувьцааны саналыг тус тус өгсөн.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай зургаадугаар хэлэлцэх асуудалд
Зөвшөөрсөн 9 санал буюу 100 хувь 24,500,312 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа
6. Охин компани байгуулах тухай долоодугаар асуудалд
Зөвшөөрсөн 9 санал буюу 100 хувь 24,500,312 ширхэг хувьцаа
Татгалзсан 0 санал буюу 0 хувь 0 ширхэг хувьцаа

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг зөвшөөрч батлав.
2. Компанийн 2020 оны санхүүгийн тайлан, түүнд хийсэн хараат бус аудитын тайлан дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны санхүүгийн тайлан тэнцлийг дор дурдсанаар батлав:
 - Нийт хөрөнгийг 41,754,633,913.99 (дөчин нэгэн тэрбум долоон зуун тавин дөрвөн сая зургаан зуун гучин гурван мянга есөн зуун арван гурван) төгрөгөөр, үүнээс эргэлтийн бус хөрөнгийг 31,623,628,781.07 (гучин нэгэн тэрбум зургаан зуун хорин гурван сая зургаан зуун хорин найман мянга долоон зуун наян нэгэн) төгрөгөөр;
 - Өр төлбөрийн нийт дүнг 7,241,131,041.61 (долоон тэрбум хоёр зуун дөчин нэгэн сая нэг зуун гучин нэгэн мянга дөчин нэгэн) төгрөгөөр;
 - Эзэмшигчийн өмчийг 34,513,502,872.38 (гучин дөрвөн тэрбум таван зуун арван гурван сая таван зуун хоёр мянга найман зуун далан хоёр) төгрөгөөр тус тус баталсугай.
 - б. Монголын цахилгаан холбоо ХК-ийн хараат бус аудитын байгууллагаар хийлгэсэн аудитын тайлан, дүгнэлтийг зөвшөөрсүгэй
3. ТУЗ-ийн Аудитын хорооны санхүүгийн тайлангийн талаарх дүгнэлтийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - а. Монголын цахилгаан холбоо ХК-ийн 2020 оны санхүүгийн тайланд хийсэн ТУЗ-ийн Аудитын хорооны дүгнэлтийг зөвшөөрч батлав.
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, сонгох тухай асуудалд кумулятив аргаар хамгийн олон хувьцааны санал авсан нэр дэвшигчдийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр сонгов.
 - а. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд нэр дэвшигчдээс кумулятив аргаар хамгийн олон санал авсан Г.Эрдэнэбулган, Т.Лхагвасүрэн, Ж.Цогтбаяр, Ч.Цэвэгдорж, Ц.Шинэхүү, М.Лхагважав нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Норовжамц, Ж.Тамир, Ю.Бат-Эрдэнэ нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс тус тус сонгов.

- b. Л.Болормааг Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүрэгт ажлаас 2021 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөр тасалбар болгон тус чөлөөлж, бүрэн эрхийг нь дуусгавар болгов.
 - c. Компанийн үйл ажиллагааг үр ашигтай удирдан зохион байгуулж, холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдэд үүрэг болгов.
5. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг батлах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - a. Монголын цахилгаан холбоо ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны зардлын төсвийг хавсралтаар батлав.
 - b. Батлагдсан төсвийн зарцуулалтад хяналт тавьж, зардал хэтрүүлэхгүй, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалинг түүний ажлын үр дүнг харгалзан олгож байхыг Төлөөлөн удирдах зөвлөлийн даргад үүрэг болгов.
6. Охин компани үүсгэн байгуулах тухай асуудлыг 100 хувийн саналаар батлав.
 - a. Эм Ти Си Сервис оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай охин компанийг /ХХК/-ийг үүсгэн байгуулав.
 - b. Компанийг үүсгэн байгуулахад оруулсан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь 1,000,000 /нэг сая/ төгрөг бөгөөд нэг бүр нь 1,000 /нэг мянга/ төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000 /нэг мянга/ ширхэг энгийн хувьцааг гаргахаар тогтоов.
 - c. Эм Ти Си Сервис ХХК нь хугацаагүйгээр дараах үйл ажиллагааг явуулсугай. Үүнд:
 - Гадаад, дотоод худалдаа
 - Түрээсийн үйл ажиллагаа, менежмент
 - Мэдээлэл, технологийн үйл ажиллагаа
 - Зуучлалын үйл ажиллагаа
 - d. Эм Ти Си Сервис ХХК-ийн дүрмийг хавсралтаар батлав.
 - e. Шинээр үүсгэн байгуулсан Эм Ти Си Сервис ХХК-ийн дүрэмд заасны дагуу тус охин компанийн Гүйцэтгэх захирлыг томилж, компани болон дүрмийг зохих журмын дагуу Хуулийн этгээдийн бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад бүртгүүлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Чинбат)-д даалгав.

ТАНИЛЦСАН:



Ч.ПҮРЭВСҮРЭН, 2021 ОНЫ ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН
ДАРГА

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Х.ЦЭЦЭГМАА, ТУЗ-ИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

2021 оны 5 дугаар сарын 03
Улаанбаатар хот.